



АУДИТЫН КОД: САГ-2017/28/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: hkosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	5
2.3	Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	6
2.5	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.6	Дотоод хяналт	7
2.7	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.8	Шилэн дансны мэдээлэл	8
2.9	Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар.....	9
2.10	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	9
2.10.1	Он удаан жил болсон авлага, өр төлбөрийг барагдуулаагүй байна	9
2.10.2	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл барьцаа хөрөнгийн дансанд байна	10
2.10.3	Ашиглалтад орсон зам, гүүрийн хөрөнгө дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байсан байна.....	10
2.10.4	Хэрэгжиж байгаа төслийн 2016 оны санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна	10
2.10.5	Төслүүдийн санхүүгийн тайлангаас дуусаагүй барилгыг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын дагуу захиалагч талын санхүүгийн тайланд бүртгэхдээ зөрүүтэй шилжүүлэн бүртгэсэн байна.....	11
2.10.6	Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн зарим дансдын үлдэгдлийг зөрүүтэй нэгтгэсэн байна	11
2.10.7	Ерөнхийлөн захирагчийн аудитаар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил.....	11
2.10.8	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын илэрсэн алдаа зөрчил, аудитын дүгнэлт	12
2.11	Залруулагдаагүй алдааны талаарх тайлбар	13
2.12	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.13	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	13
2.14	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
2.15	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
2.16	Материаллаг байдал.....	14
2.17	Хягаарлалттай санал дүгнэлт	14
3	Менежментийн захидал.....	15

3.1	Асуудал 1: Харьяа байгууллагуудын аудит хийгдсэн санхүүгийн тайлан нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрүүтэй нэгтгэгдсэн талаар.....	16
3.2	Асуудал 2: Хөрөнгө оруулалтын барьцааны баталгааны өглөгийн талаар	17
3.3	Асуудал 3: Авто замын сан ТӨҮГ орон тоо хэтрүүлэн ажилласан талаар.....	18
3.4	Асуудал 4: ТӨААН-үүд зорилтот түвшингээ эрх бүхий байгууллагаар батлуулаагүй, хуулийн хугацаанд санхүүгийн тайлан ирүүлээгүй талаар.....	19
3.5	Асуудал 5: Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил аудитын дүгнэлт талаар.....	20
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	21
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	21
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	22
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	23
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	25
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан.....	26

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 766

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

- Нийт 1,766.8 сая төгрөгийн авлага, 236.3 сая төгрөгийн өр төлбөрийг баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

- Сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангийн 5 данс санхүүгийн нэгтгэсэн тайланд 592.7 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн
- Төсөл хөтөлбөрийн 140,134.7 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй 2 санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон 386,754.8 сая төгрөгийн зам, гүүрийн үндсэн хөрөнгө бүрэн ашиглалтанд орсон боловч эдгээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн 11 төслийн санхүүгийн тайланд дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 үндсэн хөрөнгийн стандартай нийцүүлэн санхүүгийн нэгтгэсэн тайланг бодитой илэрхийлээгүй
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 604,629.5 сая төгрөгийн залруулагдах боломжгүй материаллаг алдаа зөрчил илэрсэн ба 4 байгууллага хязгаарлалттай санал дүгнэлт, 1 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзсан зэрэг нь үнэн зөв, бодитой оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй, нийт залруулагдах боломжгүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурьдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 05-наас 2017 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг нар гүйцэтгэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 4 дугаар сарын 05-ны өдрийн 01/379 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, бусад холбогдолтой хууль, эрх зүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, дээрх зарим хуулинд нэмэлт өөрчлөлт орсон.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зам, тээврийн хөгжлийн яамны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал юм.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар Зам, тээврийн хөгжлийн яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яам үйл ажиллагааны стратеги, хөтөлбөртөө Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний асуудлаар сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, сайдын төсвийн багцын төлөвлөлт, санхүүжилт, салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, гадаад хамтын ажиллагаа болон бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, зам, тээврийн хяналтыг хэрэгжүүлэх асуудлыг хамарсан стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлсон байна.

Зам, тээврийн хөгжлийн яам нь зам тээврийн салбарыг хөгжүүлэх улсын хэмжээний бодлогыг хэрэгжүүлэн, түүнийг удирдан чиглүүлэх дараах чиг үүрэгтэйгээр ажилладаг ба үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээг бий болгох, өргөжүүлэн хөгжүүлэх;
2. тээврийн дэвшилтэт технологи, тээвэр логистикийн тогтолцоог нэвтрүүлж, тээврийн үйлчилгээг хөгжүүлэх;
3. салбарын хууль тогтоомж, стандарт, норм, нормативыг шинэчилж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
4. салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;
5. хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
6. салбарын боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах

Дээрх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна, 14.1.8-д Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна гэж заасан байна.

Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад төсвийн шууд захирагч 2, төвлөрүүлэн захирагч 1, төрийн өмчит үйлдвэрийн газар 26, сан-1, нийт 30 аж ахуйн нэгж

байгууллага харьяалагддаг. Харьяа газруудаас төсвийн шууд захирагчаар 2, төвлөрүүлэн захирагч 1 /ИНЕГ- 21/, хөрөнгө оруулалтын болон, орлогын дансны 2, Авто замын сан, норм нормативын сан, төрийн өмчит үйлдвэрийн газар 26, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан 19 нийт 52 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.5 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 19 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Зам, тээврийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна. Гэвч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлал
- Төсвийн орлого, зардлын эдийн засгийн ангилал
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэр
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг асуудлууд болно.

Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг гүйцэтгэлээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.6 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод аудитын хороог салбарын сайдын 2015 оны 141 дүгээр тушаалаар 9 гишүүн, хараат бус 2 гишүүнтэйгээр баталсан байна.

Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /ХШҮДАГ/ нь 2013 оноос шинэ бүтэц зохион байгуулалтаар 25 орон тоогоор ажилладаг ба үүний 16 нь Зам, тээврийн хяналтын хэлтэст харьяалагддаг байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллаанд удирдамжийн дагуу тайлант онд нийт 12 хяналт шалгалт хийж 85 заалт бүхий 12 зөвлөмж өгч, биелэлтийг дүгнэн ажилласан байна.

2.7 ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 5 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 509,150.7 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 426,243.2 сая төгрөг, тусламжийн санхүүжилтээс 1,036.0 сая төгрөг нийт 936,429.9 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 985,079.8 сая төгрөгийн санхүүжилт авч 48,649.9 сая төгрөгөөр илүү буюу 105.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Урсгал зардалд дээрх хуулиар 92,193.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтанд 844,163.3 сая нийт 936,429.9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд зардлын зүйлүүд нь батлагдсан төсвөөс хэтрэлт, хэмнэлтийн хэлбэлзэлтэй байна.

Төсвийн зардал гүйцэтгэлээр 981,732.8 сая хүрч батлагдсан төсвөөс 45,302.9 сая төгрөгөөр хэтэрч 104.8 хувьтай байна. Үүнээс урсгал үйл ажиллагааны зардал 63,812.9 сая төгрөгөөр дутуу, хөрөнгийн зардал 109,215.4 сая төгрөгөөр илүү санхүүжигдсэн байна.

Урсгал үйл ажиллагааны төсвөөс зарцуулагдаагүй 63,812.6 сая төгрөг нь Олон улсын шинэ нисэх буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн 74,459.2 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй төсөл, хөтөлбөрийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ /зөвлөх үйлчилгээ/ гүйцэтгэлээр 19,144.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарснаас голлон шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын зардал батлагдсан төсвөөс 109,215.5 сая төгрөгөөр хэтэрсэн нь гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжиж байгаа хөрөнгийг төсөвт тусгахдаа гадаад зээлийн өрийн тогтоосон хязгаараас давуулахгүй тооцож баталдаг боловч зээлийн ашиглалт буюу гүйцэтгэл нь Сангийн ямаар дамжиж зээлийн гэрээний дагуу гүйцэтгэлээр санхүүждэгээс шалтгаалдаг байна.

2.8 Шилэн дансны мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)

4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримтад хавсаргасан ба Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд зөрчил дутагдал илрээгүй байна.

2.9 Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэж үр дүнг гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Нийт 2,003.1 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг баталгаажуулаагүй, зарим байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангийн 5 данс санхүүгийн нэгтгэсэн тайланд 592.7 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн, 2 төслийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй, 386,754.8 сая төгрөгийн зам, гүүрийн хөрөнгө бүрэн ашиглалтанд орсон боловч дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байсан, Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 604,629.5 сая төгрөгийн залруулагдах боломжгүй материаллаг алдаа зөрчил илэрсэн зэрэг нь үнэн зөв, бодитой оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй, нийт залруулагдах боломжгүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн байна

2.10 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

2.10.1 Он удаан жил болсон авлага, өр төлбөрийг барагдуулаагүй байна

Хөрөнгө оруулалтын зардлын санхүүгийн тайланд 2006-2007 онд үүссэн 18 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой, тооцоо нийлж баталгаажуулаагүй 236.3 сая төгрөгийн өр төлбөр, 1,766.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Үүнээс 134.0 сая төгрөгийн авлагыг 2014 онд хариуцагчаар гаргуулах захирамж гарсан боловч барагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Он удаан жил болсон 2,003.1 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 48 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой 480.8 сая төгрөгийн өр, төлбөр нь 4-8 жил болж баталгаат хугацаа нь дууссан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жил болсон 480.8 сая төгрөгийн өр төлбөрийн талаар холбогдох арга хэмжээ авч, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

2.10.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл барьцаа хөрөнгийн дансанд байна

“Уньт тариалан чиглэлийн 88 км авто зам барих” хэрэгжиж дууссан төслийн 866.3 сая төгрөгийн үлдэгдэл хөрөнгө оруулалтын барьцааны харилцах дансанд байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.22-т *“хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй төслийн үлдэгдэл санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын барьцааны дансанд байршиж байгаа 866.3 сая төгрөгийн төслийн үлдэгдлийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.10.3 Ашиглалтад орсон зам, гүүрийн хөрөнгө дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байсан байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон 386,754.8 сая төгрөгийн зам, гүүрийн үндсэн хөрөнгө бүрэн ашиглалтад орсон боловч эдгээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн 11 төслийн санхүүгийн тайланд дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна Мөн эдгээр хэрэгжиж дууссан төслүүдээс тайлант онд 4 төслөөс 3,661.8 сая төгрөгийн зээлийн ашиглалт гарсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-ын 26 дугаар зүйлийн 26.1-д *“дараах тохиолдолд төсөл арга хэмжээг дуусгавар болсонд тооцно”, 26.6-д “Төсөл хөтөлбөрийн нэгж нь төслийн эцсийн тайланг энэхүү журмын 12 дугаар хавсралтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, удирдлагын системд оруулах бөгөөд, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэнэ”* гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Мөн төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан дахь хөрөнгийн бүртгэл тайлагнал нь УСНББОУС-17 - Үндсэн хөрөнгө хэсгийн 14-д Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө: а) *“Хөрөнгөд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн байгууллага хүртэх магадлалтай; ...”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгжиж дууссан төслийн хөрөнгийг УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн стандартын дагуу үнэн зөв бүртгэх, цаашид төсөл хөтөлбөрийн хөрөнгө, санхүүгийн тайланг холбогдох хууль, журам, стандарттай нийцүүлэн бүртгэж тайлагнах албан шаардлага хүргүүлэв.

2.10.4 Хэрэгжиж байгаа төслийн 2016 оны санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна

“Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг паркийг нэмэгдүүлэх төсөл”, “Замын Үүдийн дэд бүтцийг сайжруулах” төсөл нийт 112,477.2 сая төгрөгийн дуусаагүй барилгын дүнтэй санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-ын 25 дугаар зүйлийн 25.5-д *“Төсөл хөтөлбөрийн нэгж нь жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн*

санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЕЗ-д хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан нь аудитад хамрагдаагүй төсөл хөтөлбөрийн талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.10.5 Төслүүдийн санхүүгийн тайлангаас дуусаагүй барилгыг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын дагуу захиалагч талын санхүүгийн тайланд бүртгэхдээ зөрүүтэй шилжүүлэн бүртгэсэн байна

Нийт 15 төслийн 523,860.4 сая төгрөгийн дуусаагүй барилга болон бусад хөрөнгийг хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд шилжүүлэн бүртгэхдээ 753.1 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, "Улаанбаатар-Хөшгийн хөндий шинэ нисэх онгоцны буудлын зам барих төсөл"-ийн 139,381.6 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг санхүүгийн тайланд нэгтгээгүй нийт 140,134.7 сая төгрөгөөр нэгтгэсэн санхүүгийн тайланг дутуу тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдаж байгаа байгууллагуудын хоорондын дүнг тулган баталгаажуулж, тооцоог баримтжуулан санхүүгийн тайланг бэлтгэж байх зөвлөмж өгч, адлааг санхүүгийн тайланд залруулав.

2.10.6 Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн зарим дансдын үлдэгдлийг зөрүүтэй нэгтгэсэн байна

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудит хийгдсэн санхүүгийн тайлан бараа материалын эхний үлдэгдэл 0.2 сая төгрөг, өр төлбөрийн эхний үлдэгдэл 3.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 325.1 сая төгрөг, тайлант үеийн үр дүнгийн эцсийн үлдэгдэл 13.5 сая төгрөг, засгийн газрын капитал дансны эхний үлдэгдэл 175.0 сая, эцсийн үлдэгдэл 75.8 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн "Нягтлан бодох бүртгэлийн зарчмын 5.1.4-д "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрүүтэй 592.7 сая төгрөгийн зөрүүг тулган шалгаж, зөв дүнгээр залруулах, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Төслийн нэгжийн тайлан болон хөрөнгө оруулалтын тайланд давхардаж тайлагнагдсан 8,968.5 сая төгрөгийн хөрөнгийн давхардсан гүйлгээг устгаагүй байгаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын 4.4-д "ТЕЗ болон түүний харьяа байгууллагуудын хооронд хийгдсэн устгагдсан ажил гүйлгээг маягт 1.1, харьяа байгууллага хооронд хийгдсэн ажил гүйлгээгээр тодруулга тайланг маягт 1.2-ын дагуу бэлтгээгүй, 4.8-д заасан 2а, б,в,г-ийн дагуу ажлын хүснэгт гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу тодруулга тайлан, ажлын хүснэгтийг бүрэн хийж тайлагнаж байх зөвлөмж өгч, зөрчлийг аудитын явцад залруулав.

2.10.7 Ерөнхийлөн захирагчийн аудитаар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил

"Авто замын сан" ТӨҮГ нь батлагдсан орон тоог 29-ээр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3."батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан орон тоо төсвийн хүрээнд зардал гарган ажиллах, Төсвийн тухай хуулийн 16.5.3-дах заалтыг хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлэв.

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК нь “Пантер мидланд” аудит ХХК-иар 2015-2016 оны аудит хийлгэхдээ Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний төлбөрийн дүнгээс 44.0 сая төгрөгөөр илүү төлж үр ашиггүй зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн: Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний үнийн дүнг баримтлан ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийт 26 ТӨААН-ээс 15 компаний зорилтот түвшинг ирүүлснээс 10 Авто зам ашиглалтын газар, Монголын төмөр зам ТӨХК зорилтот түвшингээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйл дүгээр зүйлд зааснаар ТӨБЗ-ын газрын эрх үүргийн 11.3-д *“төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр заалтыг хэрэгжүүлэн ажиллаж холбогдох эрх бүхий байгууллагаар зорилтот түвшинг батлуулж байх зөвлөмж хүргүүлэв.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв болон 8 ТӨААН нь санхүүгийн тайлангаа 1-24 хоногоор хоцроон аудитын байгууллагад хүргүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д *“Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан хугацаанд санхүүгийн тайлангаа харьяа аудитын байгууллагад хүргүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2.10.8 Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын илэрсэн алдаа зөрчил, аудитын дүгнэлт

